

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
12 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<i>№</i>	<i>Баримтын агуулга</i>	<i>Хуудасны дугаар</i>
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-24
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл 1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2019.09.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/ 2.Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2018.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	25-70 27-57  58-70

## Хураангуй тэмдэглэл

**Хоёр.Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, мөн хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Мэдээлэл, технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтсийн дарга Б.Оюумаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал С.Энхбаатар, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Нармандах, мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтох, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, мөн газрын Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Ч.Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Батболд, Хуульч, өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, референт Б.Золбоо, Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

### **Нэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал:**

**Л.Энх-Амгалан:** 1.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8 дахь заалтад нийцүүлэх гэсний дагуу 48.3 дахь заалтад доор дурдсан агуулга нэмэх:

Төслийн 48 дугаар зүйлийн 48.3 дэх хэсэгт “Цахим хуудас” гэсний өмнө “Энэ хуулийн 48.1.1, 48.1.3-т заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	17
Бүгд:	45

62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.6.4, 21.6.5, 21.6.6 дахь заалтын “ажилтан, тэдгээрийн гэр бүлийн сонгогчдын” гэснийг “ажилтны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	13
Бүгд:	46

71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	29
Бүгд:	44

34.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Нямдорж, О.Баасанхүү, Ж.Батзандан, Н.Энхболд нар үг хэлж, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам тайлбар хийв.

4.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	12
Бүгд:	44

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	30
Татгалзсан:	15
Бүгд:	45

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсөлд тусгагдсан 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах

зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	12
Бүгд:	45

73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.1.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	13
Бүгд:	45

71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“21.14.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулга ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу энэ хуулийн 21.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	31
Бүгд:	45

31.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, О.Баасанхүү, Ц.Цогзолмаа, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан нар үг хэлэв.

9.Төслийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “гаргахаас өмнө” гэсний дараа “шүүхийн шийдвэрээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	24
Бүгд:	39

38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 20 цаг 31 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл өгөв./20:33/

*Уг асуудлыг 20 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

**Бусад.**Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ж.Мөнхбат, Г.Тэмүүлэн нарын урилгаар “Мал зүйчдийн улсын зөвлөгөөн”-д Архангай аймгаас оролцож буй төлөөлөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга З.Нямцогт, мөн хэлтсийн шинжээч Р.Дэлгэрмаа, М.Номиндулам нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 3 цаг 09 минут үргэлжилж, 75 гишүүнээс 55 гишүүн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 20 цаг 34 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **Дэлгэрэнгүй тэмдэглэл**

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Сонгуулийн тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн гишүүн танилцуулна.**

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Л.Эмх-Амгалан нарын 6 гишүүнээс 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хувилбарт бэлтгэсэн хуулийн төслүүд болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.3 дахь заалтад заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал хураалгах шаардлагатай гэж үзсэн, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэл мөн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн сонгуулийн маргаан шийдвэрлэх асуудлыг тодорхой болгох зарим асуудлаар Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгийн үед санал хураалгаж шийдвэрлэлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн тосол болон Засгийн газрын тусгай сангийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Төрийн албаны тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Сонгуулийн тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж хуулийн төслүүдийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Тогтохсүрэн гишүүнд баярлалаа. Одоо Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд байвал нэрсийг нь авъя. Алга байна. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Одоо шууд Бат-Эрдэнэ гишүүний дараа шууд санал хураалт явна. 15 санал байгаа. Гишүүд хуралдааны танхимдаа ирье.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би өчигдөр энэ Сонгуулийн хуулийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх үеэр би асуусан. Тэр одоо нэг хүн рүү тухайлбал Монгол ардын хувьсгалт намын дарга Намбарын Энхбаяр гэж хүн рүү чиглэсэн ийм заалт орлоо гэж энд яригдсан шүү дээ. Тэгээд энтэй холбоотой юмыг өнөөдөр Байнгын хорооны хурлаар хэлэлцэх үү, ямархуу байдалтай байна вэ?

Би бол энэ эрүүгийн хэрэгт холбогдсон, авлигал албан тушаал тэгээд цаашлах юм бол ер нь хэрэгт холбогдсон шалгагдаж байгаа ийм хүмүүсийг энэ улс төрийн намууд бол нэлээн шалгаж үзэж байж Их Хуралд дэвшүүлэх байх гэсэн энэ байр суурь бол нэг байгаа юм. Гэтэл нөгөө талаар бол миний түрүүний асуугаад байгаа энэ асуудал нэг хүнтэй холбоотойгоор зарчмыг нь тогтоож өгөхгүйгээр ийм заалт орох юм бол болохгүй гэж 1 дэх асуулт.

2 дугаарх нь бол энэ сонгууль явуулах сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуулийн санал хураах үеэр энэ сошиалтай холбоотой юмыг ер нь цахим орчныг хязгаарлана гээд ийм асуудал яригдаад байсан. Энэ ямар зохицуулалт байна вэ? Би бол хэлээд байгаа шүү. Энэ чинь Монгол Улс бол залуучуудын орон. Энэ цахим орчныг одоо нэг өдрөөр байтугай нэг цагаар ч хаах хязгаарлах гэдэг бол төвөгтэй ийм асуудал шүү дээ. Би бас өчигдөр хэлсэн. Энэ чинь агаар ус шиг ийм хэрэгцээ болчихоод байна шүү дээ. Үүнтэй холбоотой юмыг яаж зохицуулсан юм бэ гэж.

Дараагийнх нь хамгийн сүүлд асуух гээд байгаа юм бол энэ Улсын Их Хуралд нэр дэвшигчийг ёс зүйтэй холбоотой асуудлыг яаж авч үзсэн юм бэ? Энэ чинь бол одоо яригдаад байгаа шүү дээ. Энэ Улсын Их Хурал гэдэг бол шүүхэд очихоор улсуудын хорогдох цайз болчихоод байна гэж ингэж яригдаад байна шүү дээ. Хэвлэл мэдээлэл сошиалаар тийм юмнууд яригдаад байна, тавигдаад байна.

Ер нь бол энэ Улсын Их Хуралд нэр дэвшиж байгаа улсуудаа улс төрийн намууд нэлээн сайн шалгаж шүүж байж оруулахгүй бол орсон хойноо хариуцлагатай холбоотой асуудал, ёс зүйтэй холбоотой асуудал, цаашлах юм бол хөрөнгө хогшил хураадаг ийм асуудлууд гараад байна шүү дээ. Энэ чинь одоо нэг сүүлийн 1, 2 парламентын хугацаанд яригдаж байгаа биш. Энэ 90 оноос хойш 2000 онтой зэрэгцүүлээд бол энэ ер нь нэлээн эрчимжсэн ийм асуудал шиг байгаа юм шүү дээ. Ямар хэмжээний авч байгаа нийгмийн хамгаалал баталгаа, цалин хөлстэй нь харьцуулах юм бол үндэслэлгүйгээр хөрөнгө хогшилтой болсон ийм асуудлууд тавигдаад байгаа шүү дээ.

Тэгээд ийм, ийм зүйлүүдийг нь зохицуулж өгсөн асуудлууд байна уу. Одоо нэр усыг нь хэлж яах бол төвөгтэй юм л даа. Ийм л 3 асуултад хариулж өгөөч.

**Л.Энх-Амгалан:** Тогтохсүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагч.

**Д.Тогтохсүрэн:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Өчигдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэлэлцэж анхны хэлэлцүүлэг хийх явцад Улсын Их Хурлын гишүүн Аюурсайханы гаргасан горимын саналын дагуу санал хураагаад дэмжигдсэн. Энэ нь бол авлига албан тушаалын гэмт хэрэгт тогтоогдсон бол шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихгүй гэдэг ийм заалт оруулсан. 30 дугаар зүйл дээр оруулсан юм.

Энэ асуудалтай холбогдуулаад өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлаар хэлэлцсэн. 2008 онд Үндсэн хуулийн цэц бас энэ асуудалтай холбогдуулж дүгнэлт гаргасан байдаг юм байна лээ. Тэгээд энэ асуудлыг өнөөдөр бас Байнгын хорооны хурлаар яриад энэ өчигдрийн оруулсан заалтыг хасах тийм санал оруулж Байнгын хорооны хурал дээр 2/3-ын дэмжлэг авч орж ирж байгаа. 1 дэх асуудал нь энэ байна.

2 дугаарт нь цахим орчныг хязгаарласан зүйл Сонгуулийн хууль дээр огт байхгүй. Харин цахим орчныг жаахан цэгцтэй болгох, ялангуяа сонгуулийн сурталчилгааг хийхэд тавигдах шаардлагыг жаахан өндөрсгөж өгсөн. Тухайлбал одоо сурталчилгаа хийх цахим орчин сайт бол бүртгэлтэй байна. Зөвхөн тэр бүртгэлийнхээ нэрээр явна гэдэг ийм л одоо зүйл байгаа. Түүнээс биш цахим орчныг хязгаарлах хаахтай холбоотой асуудлууд бол байхгүй байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт хийнэ. Гишүүд танхимд орж ирэх үү, одоо шууд санал хураалт хийх гэж байна. Төрийн байгуулалтын байнгын хороо сая хуралдаж дууссан учраас одоо ингээд энэ зарчмын зөрүүтэй саналын томъёолол Бямбацогт даргаа гишүүдэд тараагдчихаж байгаа биз дээ тийм ээ? Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо гар дээрээ авчих. Тэгвэл яах вэ санал хураалт хийх үү, санал хураалт хийх үү? Тогтохсүрэн даргаа санал хураалт. Гишүүд хуралдааны танхимд одоо шууд санал хураалтууд эхлэх гэж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт хийнэ.

1.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8 дахь заалтад нийцүүлэх гэсний дагуу 48.3 дахь заалтад доор дурдсан агуулга нэмэх:



Төслийн 48 дугаар зүйлийн 48.3 дэх хэсэгт “Цахим хуудас” гэсний өмнө “Энэ хуулийн 48.1.1, 48.1.3-т заасан” гэж нэмэх. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна. Санал хураалт гишүүдээ. Санал хураалт. 14-хөн санал хураалт байгаа гишүүдээ. 45 гишүүн оролцож 28 гишүүн зөвшөөрч 62,2 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

2.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.6.4, 21.6.5, 1.6.6 дахь заалтын “ажилтан, тэдгээрийн гэр бүлийн сонгогчдын” гэснийг “ажилтны” гэж өөрчлөх. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна. Санал хураалт. 46 гишүүн оролцож 33 гишүүн зөвшөөрч 71,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

3.Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглох бөгөөд эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс нь гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” Төрийн байгуулалтын. Бямбацогт гишүүн, Байнгын хорооны дарга.

**С.Бямбацогт:** Бишээ биш. Энэ Байнгын хороон дээр хураагдсан бол эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно гэсэн томьёолоор хураагдсан. Гэтэл дээд талд нь өөр өгүүлбэрүүд. Энэ өөр юм, надад өөр юм өгсөн юм уу?

**Л.Энх-Амгалан:** Тамгын газар энэ дээр.

**С.Бямбацогт:** Байнгын хороон дээр хураасан санал ... /үг тасрав/

**Л.Энх-Амгалан:** Санал хураалт хийсэн томьёолол нь өөрчлөгдөж орж ирсэн байна гэж байна шүү дээ. Бямбацогт, Байнгын хорооны дарга Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Байнгын хороон дээр хураагдсан саналын томьёолол бол 28.10 эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно гэсэн саналыг Болд гишүүн гаргаад ингэж явсан. Ингэж хураагдсан. Гэтэл тараагдсан материал дээр өөр тараагдсан байна. Тэгэхээр уншихгүй тийм.

**Л.Энх-Амгалан:** Тэгвэл юу яах нь байна. Ингээ тэгэх үү өмнөх нь, Нямдорж сайд. Баасанхүү гишүүн. Нямдорж сайдын микрофоныг. Нямдорж гишүүний.

**Ц.Нямдорж:** Тэр Байнгын хороон дээр тэгж санал хураагдсан юм бол дундаас нь хүн зохиогоод юм бичээгүй байлгүй. Яг энэ бичээд оруулаад ирсэн юм чинь бол гарцаагүй л юмнууд бичигдсэн байна. Сонгууль эхлээд дуустал эвсэл гэдэг юм чинь нэгээрээ байгаад дуусах ёстой юм. Эвсэлд нэгдчихээд өөрсдөө өөр, өөр данстай байгаад байж болдоггүй юм. Цугларсан мөнгийг нь өөр, өөр дарга нар зараад байж болдоггүй юм. Дангаараа нэр дэвшүүлж болдоггүй юм.

Энийгээ эрх биш ойлгож байгаа биз дээ. Одоо асуудал яригдаж байгаа бол хэн дураараа юм бичсэн юм бэ гэдэг л асуудал яригдана л даа. Тэгээд олонх нь эвслээс гарсан гэдэг чинь бас буруу хууль зүйн хувьд бол. Эвсэл нэг л задарвал

олонх цөөнх байдаггүй, зүгээр бүтэн задардаг. 3 нам нэгдэж эвсэл болчихоод нэг нь гараад явчих юм бол эвсэл чинь байхгүй болдог. Яагаад вэ гэхээр нэр дэвшүүлэх 3 нам чинь 1/3 гэсэн л байж таараа ойролцоогоор. Тэгээд тал хувь нь 30 хувь нь гараад явчихаар чинь эвсэл чинь өөрөө байхгүй болчихдог л асуудал шүү дээ. Энэ хууль бичнэ гэдэг юм чинь цаад болох процессоо дандаа харчхаад бичдэг эд шүү дээ. Үгүй ээ үгүй хариулаад байх юм байхгүй.

Наана чинь жишээ нь олонх гэхээр юу гэж ярих юм бэ? 5 нам нийлээд эвсэл боллоо гэхэд 3 нь гарахад эвсэл тарна, 2 нь гарахад тарахгүй гэж үзэх юм уу? Ингээд бүх юм чинь дампуурна. Тэгээд сонгуулийн явцад ийм улс төрийн маргааны хуулийн сэдэв бий болгож өгөөд. Гудамжинд цөмөөрөө гараад сонгууль ч байхгүй дуусах ийм аюул байна шүү дээ. Яг энэ ороод ирсэн томьёолол гарцаагүй юм бичигдсэн байна. Эвсэл гэдэг юм чинь сонгуулийн өмнө нэг эвсээд л тэгээд л дуусдаг. Хэд хэдэн удаа эвсэл болж байсан. 96 онд болж байсан. 2004 онд болж байсан. 2008 онд болж байсан. 12 онд болж байсан. 16 онд чинь яалаа даа. Энэ эвслийг ийм хэврэг болгож болохгүй. Энэ чинь тоглоом биш шүү дээ.

Нэг өдөр эвсэлд нэгдлээ гэж орчхоод маргааш нь баахан мөнгө шантаажилж байгаад гарчхаад л. Дараачийнхтайгаа очиж дахин эвсээд л, сонгуулийн явцад байнга энэ чинь яагаад явчихна. Тоглоом хийгээд явчихна. Ийм тоглоом хийдэг бэлэн хүмүүс ч байгаа, нам ч байгаа. Энэ юмнуудаа та бүхэн хэрэв Байнгын хороон дээрээ яриад ойлголцоогүй юм бол дахиж Байнгын хороогоо цуглуулаад энэ улс төрийн будилаантай юмаа нэг мөр болгож орж ир. Ажлын хэсгийн ахлагч ингэж буруу тийшээ зүтгүүлж болохгүй. Тэгвэл энэ томьёоллоороо дахиад хуралд. Үгүй ээ үгүй Тогтохсүрэн даргаа. Би та нараас биччихсэн хуулийн томьёоллоор хариулт сонсох дайны тийм жижигхэн ойлголттой хүн биш шүү дээ. Би гарцаагүй юм ярьж байна шүү дээ. Би гарцаагүй юм ярьж байна.

Нэг л эвсэл болохоороо тэгээд л эхлэлээ дуустал хамт явах ёстой юм. Олонх гэдэг чинь хүртэл болохгүй байгаа байхгүй юу. Та бүхэн дахиад нэг энийгээ бод л доо. Тайлбар өгөхөөсөө өмнө. Энэ Сонгуулийн хууль бол бусад хуультай харьцуулахад улс төрийн тогтворгүй байдал үүсгэх дээд зэргийн магадлалтай аюултай хууль шүү. Энэ хуулийн үг үсэг болгоны цаана улс төрийн тэмцэл маргаан явагддаг учраас алдаагүй юм, гарцаагүй юм хийхгүй бол нөгөө шүүх дээр чинь очоод тэгээд сүүлд нь эвсэл задарсан гээд маргалдаад эхэлнэ. Задраагүй гээд маргалдаад ... /минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Одоо гишүүдээ ийм байгаа шүү дээ эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа шүү дээ. Эцсийн хэлэлцүүлэг хийх чинь өөрийн бас дэгтэй. Одоо тэгэхээр Нямдорж сайдын саяын ярьсан дээр бол бид нар Байнгын хорооны дарга үг л хэлнэ шүү дээ. Тэрнээс хариулт биш байхгүй юу, асуулт, хариулт биш шүү дээ энэ чинь үг хэлж байгаа тийм. Баасанхүү гишүүн хэлчих.

**О.Баасанхүү:** Би яах вэ энийг ингээд харж л байна л даа. Хүмүүст байдаг л зовлонгийн нэг. Мэдээж одоо юу вэ гэх юм бол огт хууль санаалагчийн зүгээс орж ирээгүй. Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гараагүй тохиолдолд ингэж хулгайн байдлаар орж ирэхэд хэдийгээр сайн заалт байсан ч гэсэн хэцүү.

2 дугаарт нь эвсэл нэгдэх эвсэл задрах гэдэг энэ бол бас төвөгтэй. Манайд өнөөдөр 34 нам байгаа ч гэсэн янз бүрийн хуурамч намууд ордог, ингэдэг тэгдэг. Сонгуулийн үр дүнг өөрчлөх гээд байдаг байхгүй юу. Бүлэг задрахаас ч төвөгтэй асуудал үүснэ л дээ. Тэгээд эвсэл задарлаа гээд томсгосон тойрог дээр эвсэл

задарлаа гэнгүүт нь эвслийн гишүүн юм уу эсхүл одоо намын гишүүн юм уу? Хэн нь үлдэх юм бэ гэдэгтэй адилхан юм болчихоод байгаа юм л даа.

Яагаад гэхээр эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэхгүй гээд бичсэн байна шүү дээ. Эвслийн аль нэг нам дангаараа дэвшүүлэхгүй гэж байгаа юм чинь эвсэл гэж байхгүй бол энэ хүн нэр дэвшээгүй гэж л дайрах нь байна шүү дээ. Энэ өгүүлбэрийг бас аягүй сайн бодох гээд байгаа байхгүй юу. Хэдийгээр одоо би хувьсгалт намын гишүүн байна гэж бодъё. Тэгээд эвслийн шугамаар юу гэдэг юм сонгуульд ороод ялсан гэж бодъё. Тэгэнгүүт эсвэл задарсан юм чинь энэ хүн Их Хурлын гишүүн биш. Яагаад гэвэл энэ нам дэвшүүлээгүй. Эвсэл дэвшүүлсэн. Нам дангаараа дэвшүүлэхгүй гэдэг энэ үгээр нээнтэг хийгээд Үндсэн хуулийн цэц рүү хандахад бол болохгүй юм байхгүй шүү дээ.

Би намын л гишүүн болохоос тэгээд бид эвслийн мөнгө, эвслийн одоо зардал, эвслийн хамаг юмаар л явсан шүү дээ гээд л дайраад байдаг. Би болохоор юу гэдэг юм намайг одоо дугуйлсан шүү дээ гээд дайраад байдаг. Тэгээд бие даагч болох юм уу? Энэ ерөөсөө ингээд нөгөө нэг сонгох, сонгогдох гэдэг шиг нэр дэвшүүлэх, хиймэл субъект гаргаад байна л даа. Хиймэл субъект. Өөрөөр хэлэх юм бол би юу гэж бодож байгаа вэ гэвэл нэр дэвшүүлээд л орхисон. Сонгосон нь бол ард түмэн шүү дээ. Тэгээд ард түмэн нэгэнт сонгож байгаа бол тэр ард түмний сонголтыг өнөөдөр чи эвсэлд байсан байна уу, намд байсан байна уу хамаагүй тэр чинь ард түмэн сонгосон учраас үлдэх ёстой.

Гэтэл энүүгээр бол дэвшүүлэх эрхгүй гээд тавьчихаж байгаа болохоор маш осолтой шүү гэдгийг би анхаараасай гэж хүсэж байна. Тэр олонх эвслээс гарсан тохиолдолд гэдгийг бол энийг яах ёстой вэ, олонх гэдгийг юу гэж ойлгох юм бэ? 2 нам эвсэх юм бол аль нь олонх юм бэ? Олон гишүүнтэй нь юм уу? 3 болчих юм бол 1 нь гараад 2 нь үлдэх юм бол эвслийнхээ нэрийг аваад явна гэсэн санаа гараад байна л даа тийм ээ.

4 болчих юм бол одоо юу гэдэг юм 2, 2 болохоор аль нь олонх болох юм бэ? Ингээд тэгш тоон дээр олонх гэдэг ойлголт чинь өөрөө хэцүү болдог юм. Сондгой тоотой нь бол ойлгогдоод байна. Тэгш тоон дээр бол. 6 байлаа гэхэд 3 нь гаръя гээд шийдсэн. 3 нь үлдсэн учраас хүчингүй. 3 нь гарах юм бол 5 нь үлдье гэх юм уу? Энийг сайн эргээд бас харах цаг болсон гэж хэлмээр байна. Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Бямбацогт гишүүн Байнгын хорооны дарга.

**С.Бямбацогт:** Сая Нямдорж гишүүн хэлж байгаа, Баасанхүү гишүүн хэлж байгаа агуулга бол адилхан. Агуулга, зорилго адилхан. Гэхдээ энэ заалтыг бид нар тийм хураахдаа эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно гэж байгаа юм олонх нь. Ийм үгээр өнөө өглөө хураасан. Энэ саналыг Батзандан гишүүн гаргасан, Болд гишүүн гаргасан. Өөрсдийнхөө саналыг ингэж өөрчилье гэж томъёолсон.

Энэ дээр яасан бэ гэхээр эвсэлд 10 нам эвсэж болно. 10 нам эвсээд сонгуульд орж явж байгаад 1 нам эвслээс гарлаа гэдэг. Цаад 9 нам нь үндсэндээ тэгэхээр сонгууль оролцох эрхээ эдэлж чадахгүйд хүрнэ. Улс төрийн намуудыг эвсэх нэгдэх, сонгуульд хамтарч оролцох бололцоог ганцхан намаас болоод тийм ээ 10 намаас 1 нь гарахад нөгөө 9 нь сонгууль оролцох бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй болчих ийм эрсдэл байгаа учраас олонх нь гаръя.

Хэрэв тэр 10 намаас 6 нам нь эвсэл тарья гэж үзэх юм бол тэр эвслийг тарсанд тооцъё. Тэгэхгүй 10 нам дотор 1 нам шургаж орчхоод нэг нам нь гараад явчих юм бол 9 нам нь сонгуульд оролцох эрхээ эдэлж чадахгүйд хүрэх нь. Тийм болохоор улс төрийн намуудыг эвлэлдэн нэгдэх, Үндсэн хуулийн тэр эрхийг зөрчиж байгаа заалт учраас эвсэлд орсон намуудын нэг намыг гарахыг хориглоно. Хэрэв гарах юм бол эвслийг тарсанд тооцно гэсэн заалт бол хэтэрхий Үндсэн хууль зөрчсөн заалт болсон байна гэдэг агуулгаар бид нар олонх нь гарья гэж үзэх юм бол гэж оруулсан юм.

Ингэж Байнгын хороон дээр орсон томъёоллыг хаана яагаад өөрчилсөн бэ би бас гайхаад байна тийм. Батзандан гишүүн санал гаргасан та бас өөрөө тайлбарлачих. 2 саналыг хоёуланг нь Батзандан гишүүн гаргасан.

**Л.Энх-Амгалан:** Батзандан гишүүн. Одоо бид нар тайлбар сонсохгүй шүү дээ. Одоо эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа шүү дээ. Тайлбар сонсохгүй шүү дээ.

**Ж.Батзандан:** Монгол Улсад улсын бүртгэлтэй 34 нам байгаа юм. Парламентад суудалгүй байгаа 30 гаруй намууд нэгдэж 20 гаруй саналыг Сонгуулийн хуультай холбоотой гаргасан боловч 1 ч санал дэмжигдээгүй. Иргэд олон түмэн парламентын гадна байгаа намууд их бухимдалтай байгаа юм. Эцэст нь нэг л саналыг хэлж байгаа юм. Одоо сонгуулийн эвсэл гэдэг бол 30 жил эвлэлдэн нэгдэхийн эсрэг бодлого Монголд явсан. Монголчуудыг хагалан бутаргах бодлого 30 жил явсан. Эвсэл гэж нэг юм байгуулдаг сонгуулийн өмнө нэг нам нь гардаг. Эвсэл тардаг. Монголчуудын сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүй байдал олон жил үргэлжилсэн. Энийг зогсоож өгөөч.

Ядахдаа эвссэн намуудынх нь олонх нь 51 хувь нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсан гэж үздэг ийм тогтолцоо руу орж өгөөч гэж намууд хүсэж байгаа юм. Европын аюулгүй байдлын зөвлөл хүний эрхийн байгууллагууд ч гэсэн Монгол Улс одоо эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжих нь зүйтэй гэдэг саналыг бас зөвлөмж маягаар бидэнд хүргүүлсэн байгаа. Тэгэхээр эрх баригч намын удирдлагуудад мөн Их Хурлын даргын сонорт энийг хүргэснээр өчигдөр Улсын Их Хурлын даргын дарга Занданшатарын чиглэлийн дагуу энэ өөрчлөлт орж Байнгын хороон дээр 28.10 буюу эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно гэдэг ийм агуулгаар оруулъя гэдэг санал дэмжигдэж орж ирсэн юм.

65 суудалтай эрх баригч нам Монголын бусад жижиг намуудаа эвлэлдэн нэгдэж сонгуульд ороход нь туслалцаа үзүүлээч гэж дэмжлэг үзүүлээч гэж хүсэж байна. Сонгуулийн хууль бол сонгогчдын хууль юм. Эвлэлдэн нэгдэх эрхийн тухай хууль учраас дэмжиж өгөөч гэж хүсэж байгаагаа илэрхийлье. ШИНЭ намын хувьд олон бусад гадаа гудамжинд байгаа намуудаа бас сонгуульд хамтарч ороход нь туслах зорилготой байгаа гэдгээ бас хэлэхийг хүсэж байна.

**Л.Энх-Амгалан:** Тамгын газар тайлбараа хэлэх үү? Одоо энэ чинь ерөөсөө юу яаж байна шүү дээ. Эсхүл одоо энэ заалт будилаантай ямар нэгэн ойлгомжгүй байх юм бол унагах. Эсхүл дэмжих. Дэмжихдээ бид нар одоо яг энэ оруулж ирсэн санал хураалгасан юугаар л бид нар уншиж санал хураалгахгүй бол болохгүй шүү дээ. Тамгын газар тайлбар хэл дээ. Тийм. Эсхүл өргөн барьснаараа явна. Тийм. Өргөн барьсан хувилбараараа явах үлдэх ийм л юу байгаа шүү дээ энэ унах юм бол. Нямдорж сайд.

**Ц.Нямдорж:** Гишүүд минь би гишүүдийн санаа зоволтыг ойлгож байна Батзандан гишүүний өөрийн чинь жишээ. Гэхдээ та нар энэ эвсэл гэдэг юм чинь юу болж байсан түүхээ битгий мартаарай. Энэ эвсэл гэдэг юм чинь хэврэг юм байгуулагдчихаад сонгуулийн хувьд ч хэврэг юм хийгээд сонгуулийн дараа ч төрөөр бүтэн 4 жил тоглоод ингээд өнгөрсөн 3 удаагийн туршлага бид нарт байгаа шүү дээ. 96 оны ардчилсан эвсэл юу болсон билээ. 2004 оны маш сайн намтай нийлсэн эвсэл юу болсон билээ? Хэдэн Засгийн газар солигдлоо. Хамгийн сүүлд 2012 он Шударга ёс эвсэл юу болсон билээ? Энэ нэг эвссэн бол 4 жил эвссэн байдлаараа ажиллаж, улс төрийн тогтвортой байдлыг хадгалж байх явдал бол энэ ёстой намын асуудал биш шүү. Энэ төрийн асуудал шүү.

Тийм учраас та бүхэн энийгээ тэр Байнгын хороон дээрээ дахиж яриач. Сонгуулийн хууль зовлонтойг ойлгохын дээдээр ойлгож байна. Хэзээ л бол хэзээ л тарж байдаг эвсэл хийж өгчхөөд сонгуулийн явуулаад үр дүнд нь юу болдог билээ? Энэ зовлонг бид нар бүгдээрээ дайраад өнгөрсөн шүү дээ. Эрх барьж байсан нь ч энийг энэ зовлонг дайрсан. Цөөнх байгаа энэ сөрөг хүчин байсан нь ч бүгдээрээ л бид нар хамт энийг үзээд өнгөрүүлсэн 30 жилийн түүх байна шүү дээ. Энийгээ л бодоорой. Надад өөр хэлэх юм алга. Энэ эвслийн асуудалд эвссэн бол эвссэн. 4 жилдээ хамтдаа бай л гэсэн зарчим шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** Тэгвэл санал хураалт хийчих үү? Баасанхүү гишүүн товчхон хэлнэ шүү.

**О.Баасанхүү:** Энэ хараа би ганцхан зүйл хэлээд байгаа шүү дээ. Эвсэлд мэдээж ороод 9 нам орлоо гэж бодоход 1 нь гарахад 8 нь үлдмээр байгаа нь зөв. Гэтэл 9-ийн дундаас ганцхан Их Хурлын гишүүнтэй эвсээд, эвсээд ганцхан гишүүн гарлаа гэсэн магадлал гараад ирвэл тэр гишүүнтэй нам нь гаръя гээд шийдвэр гаргавал яах юм бэ? Цаад үлдсэн 8 нь Их Хурлын гишүүнгүй эвсэл болчихоод байгаа байхгүй юу. Манай одоо нам өөрийнхөө гишүүнээрээ дамжуулаад эвслээс гарах шийдвэр гаргалаа гээд алх цохидог. Нөгөө 8 нь хүрч ирээд бид нар эвсэл хэвээрээ гээд байдаг. Ингэхээр чинь байдал өөрөө хачин болоод явчхаж байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ эвсэл тарвал баривал гээд байдаг асуудал чинь ерөөсөө энийг яриад байгаа байхгүй юу. Тийм биз дээ. Өөрөөр хэлэх юм бол хэдэн гишүүн сонгогдох нь ойлгомжгүй. 9 нам дотроос 9-лээ нэг, нэг хүнийг дэвшүүлээд юу гэдэг юм 76 хүн дотроос 9 нам болгон нэг, нэг юутай гэвэл магадлал огт байхгүй шүү дээ. Ийм байгаа болохоор энийг бол их дахиж харах ёстой болчихоод байгаа юм. Тэрнээс биш би энэ эвслийн олонх, цөөнх гэдэг дээр байгаа биш. Хууль зүйн тэр магадлалыг гаргахгүй бол сүүлдээ тийм хошин юманд орох вий. Гишүүнтэй хэсгүүд нь гарлаа гэж хэлээд, гишүүнгүй хэсэг нь эвсэлтэйгээ үлдчих вий дээ л гэж санаа зовоод байна шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** Нямаагийн Энхболд товчхон хэлчих.

**Н.Энхболд:** Би товчхон энэ хэлье. Энэ сая Баасанхүү гишүүний яриад байгаа чинь сонгууль болоод өнгөрсөн хойно гишүүн сонгогдсон хойно болоод байгаа юм яриад байна шүү дээ. Тэгээд тэр 1 гишүүнтэй эвсэл байж байгаад тэр нь эвсэнэ үү, тарна уу, тарахгүй байна уу? Онцын ялгаа байхгүй шүү дээ. Эвсэл гэж нэрнээс л цаашгүй нэг хүн яах юм бэ, бүлэг л байхгүй бол өөр шүү дээ. Ямар ч ялгаагүй. Зүгээр энэ би зүгээр хэний Бямбацогт даргаа би таны ярьж байсныг харж байна хар даа.

28.10 дээр угаасаа саяын үгнүүд нь урдаасаа бүгд байж байгаа байхгүй юу тийм ээ. Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх энэ бие даан зардал гаргах ийм юмыг гэсэн бол тарсан гэж үзнэ гээд. Энэ чинь угаасаа байж байгаа юм. Анхны нөгөө төсөл дотор байж байгаа. Энэ дотроосоо л нэг нам нь шийдвэр гарсан бол гэдгийг олонх гэдэг үг орсон юм. Энэ ярьж байгаад орсныг нь би мэдэж байна. Яагаад ажлын хэсгийн гишүүний хувьд над дээр хүмүүс ирээд саяын яг Занданшатарын, Батзандан гишүүний ярьсан ийм юмнууд ярьсан юм. Тийм ээ? Сонгуулийн явцад анхнаасаа хэдэн нам нийлж орчхоод зориудаар Нямдорж гишүүний хэлдэг шиг энийг байхгүй болгоё гээд нэг нь юм уу хоёр нь гарчихад ингээд бүгдээрээ хохирчих гээд байгаа ийм тохиолдолд та нар ядаж олонх нь үлдсэн тохиолдолд тэр эвсэл сонгуульдаа ороод явдаг. Орсон хойноо эвсэл нэртэй явдаг гэсэн ийм нөхцөлийг хангаж өгөөч л гэсэн юм яриад байсан юм.

Тэгж яриад л би Байнгын хороон дээрээс ийм шийдвэр гарсан гэж бодож байна. Яг энэ шийдвэрийг Байнгын хороон дээр гарахад би байгаагүй л дээ. Тэгэхээр одоо энэ бол эцсийн хэлэлцүүлэг. Одоо бид нар энийг унагаавал 1 нам гэдэг нь л үлдэнэ. Яг хуучин заалтаараа. Бүх юм нь хэвээрээ үлдэнэ. Ганцхан нэг нам нь гэдэг нь үлдэнэ. Олонх нь гэдэг бол унана. Ер нь бол би тэр үед нь хэлж байсан юм. Энэ намуудад. Та нар эвсэл болох гэж байгаа юм бол эхнээсээ л тэрнээсээ гарахгүй намуудтай эвсэх ёстой. Тэгж чадахгүй бол тийм эвсэл байж хэрэггүй шүү дээ гэж хэлж байсан.

**Л.Энх-Амгалан:** Ингэе тэгэх үү. Одоо ерөөсөө бид нарт 2 л зам байгаа шүү дээ. Нэг нь дэмжье. Нөгөөх нь бол дэмжихгүй байя. Дэмжихгүй бол унаж байгаа. Унахад бол унасан тохиолдолд хууль санаачлагчийн өргөн барьсан хувилбараар бол эвсэл тийм ээ, яаж байгуулагдах вэ, яаж задрах вэ гэдэг зохицуулалт бол байгаа. Тэрүүгээрээ үлдэх. Гэхдээ энэ бол бас дараа нь 20 оны сонгуулийн нөхцөл байдалд нэлээн бас бид нар юу болохыг мэдэхгүй шүү дээ. Тийм учраас Бямбацогт даргаа? Байнгын хороо дахиж хуралдаад яг зөвхөн энэ асуудал дээр Байнгын хороо дахиж хуралдаад. Тамгын газар нэг тайлбар хэлье. Үгүй ээ би бол угаасаа Байнгын хорооны саналыг л хураалгана шүү дээ. Өөр ерөөсөө шийдэл байхгүй.

Тамгын газрын нэг тайлбарыг сонсьё. Тамгын газар. Бид нар 20 онд бас юу ч болохыг бид нар одоо бол тааж мэдэхэд хэцүү шүү дээ. Тийм учраас Тамгын газар тайлбараа.

**Ж.Бямбадулам:** Байнгын хороон дээр Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” гэж ингэж санал хураалгасан байгаа.

**Л.Энх-Амгалан:** Тэгээд энэ яагаад энэ ийм юу аваад ирж байгаа юм бэ? Тэгээд над дээр одоо ирж байгаа энэ санал хураалгах гэж өгч байгаа юу чинь юу байна шүү дээ. Одоо тэгвэл наад юугаа надаар уншуул л даа одоо.

**Ж.Бямбадулам:** За.

**Л.Энх-Амгалан:** Үгүй энэ чинь зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг би уншиж санал хураалгаж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо наад саналын томъёолол чинь надад ирэх ёстой шүү дээ. Гишүүдэд бас, гишүүдэд ирэх ёстой шүү дээ.

Гишүүдэд ирж байж наана санал хураалтууд явагдана шүү дээ. Наад томьёоллоо аваад ир. Одоо тэгвэл ерөөсөө яг энэ Байнгын хороон дээр бид нар санал хураалгасан томьёоллоор л санал хураалгах ёстой шүү дээ. Зөв биз дээ. Одоо би Байнгын хорооны хамгийн сүүлд зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншъя. Яг энүүгээр санал хураалт хийнэ шүү. Одоо энэ 3. Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” Байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт. Одоо санал хураалт. Байнгын хорооны дэмжсэн санал байна шүү дээ. Энэ санал дэмжигд, 44 гишүүн оролцож 15 гишүүн зөвшөөрч 34,1 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Байнгын хорооны санал унаж байна гэсэн үг шүү дээ. Өргөн барьсан нь үлдэж байгаа.

4.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт. 44 гишүүн оролцож 32 гишүүн зөвшөөрч 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

5.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.” Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт. 45 гишүүн оролцож 30 гишүүн зөвшөөрч, 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

6.Төсөлд тусгагдсан 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна. Санал хураалт. Сонгуулийн хуулиа орж ирж баталсан гишүүд нь сонгуульд их олон сонгогддог гэж Их Хуралд олон сонгогддог гэж манай ахмад гишүүд их хэлж байгаа юм байна. Тэгээд гишүүд орж ирж саналаа өгөх ёстой байх. 45 гишүүн оролцож 33 гишүүн зөвшөөрч 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна. Сонгуулийн хуулиа баталсан гишүүд нь дахин сонгогддог юм байна түүхээс.

7.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.1.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. 45 гишүүн оролцож 32 гишүүн зөвшөөрч 71,1 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

8.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“21.14.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулга ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу энэ хуулийн 21.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгоно.” Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна. Содбаатар гишүүн.

**Я.Содбаатар:** Энэ урд талын энэ асуудлаар чинь бол урд талын Сонгуулийн хуульд байсан л даа. Тэгээд сая Улсын бүртгэлийн тухай хууль чинь өөрчлөгдөөд энэ чинь 1 дүгээрт хууль зөрчиж байгаа юм биш үү. Одоо байгаа хүчин төгөлдөр хуулиар. Өгч болж байгаа юм уу? 2-т болохоор бол энэ өгдөг юмаа гэхэд энэ хүний оршин суугаа хаяг, регистрийн дугаарыг нь өгөх ямар хэрэгтэй юм бэ? Энэ чинь цаана нь энэ чинь бас энэ улсын аюулгүй байдалтай холбоотой шүү дээ. Энэ чинь хүмүүсийн мэдээллийг сан. Зүгээр тэр одоо овог, нэрийг нь олж авах гээд байгаа бол тэгээд олж аваад л тэр нь ямар хэрэгтэй юм бэ тэгээд л авна биз. Заавал тэр хүний хаягийг нь авч яах гээд байгаа юм бэ? Тийм. Үгүй ээ үгүй харин тийм. Тэгээд энэ чинь Бүртгэлийн хууль дээр өнгөрсөн жил бид нар энийг чинь хаасан шүү дээ.

Одоо энэ Баасандорж дарга Бүртгэлийн дарга хэлэх хэрэгтэй шүү дээ. Үгүй ээ үгүй Бүртгэлийн хаачхаад одоо энийгээ эргэж ямар. Үгүй ээ үгүй Бүртгэлийн хуулиа зөрчиж энэ хууль батлах гээд байгаа юм уу? Хүчин төгөлдөр хууль зөрчиж энэ хууль баталдаг юм уу? Эрдэнэбатаа. Хууль зөрчиж хууль баталж болохгүй Эрдэнэбатаа.

**Л.Энх-Амгалан:** Баасанхүү гишүүн. Энэ гэхдээ хувь хүний нууцтай холбоотой энэ мэдээлэл чинь яг зохицуулагдах юм бэ?

**О.Баасанхүү:** Баярлалаа. Үгүй ээ яах вэ тэгээд тэр юмыг нь өгчхөөч дээ. Өгчхөөд. Тэгээд хэрэглэнэ, яаж хэрэглэдэг тэр аргаараа л хэрэглэе л гэж байгаа юм биш үү. Би бол тэр дээр бол маргаад яах вэ дээ л гэж бодож байна. Харин би шал өөр зүйл хэлэх гээд байна. Энэ Байнгын хороон дээр дэмжсэн эсхүл Байнгын хороон дээр дэмжээгүй санал чинь нэгдсэн чуулганаар заавал орж ирж дэмжсэн, дэмжээгүйгээрээ баталгааждаг явна шүү дээ.

Огт байхгүй байгаа заалтыг одоо ингээд байхгүйгээр нь оруулаад ямар нэгэн байдлаар юмаа үлдээчих юм бол өмнөх нэгдсэн чуулганаар батлагдсанаараа хүчинтэй гэж үзэх юм уу? Энэ Сонгуулийн хууль чинь бүхлээрээ хүчингүй гэх юм уу? Сая одоо би нэг зүйлийг их сонин зүйл ажиглалаа л даа. Байнгын хороон дээр яриагүй зүйлийг Тамгын газар оруулж ирлээ гээд энийг одоо ямар ч асуудалгүйгээр за, тэнд ярьсан юм байна гээд ингэсэн. Одоо энийг ингээд харсан чинь хэд хэдэн одоо яриад байсан заалтууд чинь энэ дотор алга байна шүү дээ.

Тэгэхээр энэ алга байгаа заалтыг нэгдсэн чуулган дээр оруулж ирэх ёстой юм уу, ёсгүй юм уу, тэгээд ёсгүй юм бол одоо Нямдорж гуай бол хэлэх хэрэгтэй байгаа юм л даа. Хэрэв яг ийм тохиолдолд өмнөх нэгдсэн чуулганаар баталсан юмаа хүчинтэй гэж үзэх үү. Энийг одоо эсхүл Байнгын хороо нэгдсэн чуулганаасаа илүү давуу эрхтэй юм уу? Энэ дээр би хууль санаачлагч нараас асуумаар байна.



**Л.Энх-Амгалан:** Одоо асуулт байхгүй л дээ. Цогзолмаа гишүүн.

**Ц.Цогзолмаа:** Энэ асуудал нь үндсэндээ бол бас сонгуулийн үеэр иргэд сонгогчдын дунд ч юм уу улс төрийн намууд яг сонгуульд оролцож байгаа хүмүүс, хуулийн этгээдийн хувьд бас л асуудал дагуулдаг асуудал л даа. Хэрэв батлагдсан хуулийг зөрчиж байна гэж үзвэл яах ёстой вэ гэдгээ бодох ёстой байх. Энэ чигээр нь батлаад явах ёстой гэвэл редакцын шинж чанартай нэг санал хэлэх гэсэн юм.

21.9-т сонгогчдын нэрийн жагсаалт гээд нэрсийн жагсаалт байх. Ийм саналыг нэмж байна.

**Л.Энх-Амгалан:** Пүрэвдорж гишүүн. Санал хурааа. Тэгэх үү. Энэ бол нэг их дэмжих тийм хэрэггүй санал юм байна. Юу гэхээр бас тодорхой хувь хүний нууцтай холбоотой асуудал учраас бол. Санал хураалт. Дэмжих шаардлагагүй. Яагаад гэвэл энэний зохицуулалт хууль санаачлагчийн өргөн барьсан дээр зохицуулалт байгаа шүү дээ. тийм. Юу гэсэн үг юм бэ? Байнгын хороон саналаар санал яаж байна шүү дээ. Тийм. 45 гишүүн оролцож 14 гишүүн зөвшөөрч 31,1 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

9.Төслийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “гаргахаас өмнө” гэсний дараа “шүүхийн шийдвэрээр” гэснийг хасах. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт. Үгүй ээ юу гэсэн үг юм бэ? Санал хураалт хийж байна шүү дээ. Би хууль санаачлагч шүү дээ. Би хууль санаачлагч тийм. Санал хураалт. Энэ 9 дүгээр санал дахиад унаж байна шүү дээ гишүүд ээ. Бямбацогт гишүүн. Ойлголцъё. За.

**С.Бямбацогт:** Гишүүдээ тайван байж байя. Үнэхээр ийм байдлаар хуралдаж болохгүй. Ингэж хуралдахгүй ээ. Сонгуулийн хуулийг ингэж батлахгүй. Энэ үнэхээр бас нэлээн сайн нухацтай ярилцахгүй бол болохгүй заалтууд байгаа. Ярилцаад, зөвшилцөөд, ороод ирсэн саналууд дандаа ингээд эсрэгээрээ явж байгаад харамсаж байна. Тараасан зарчмын зөрүүтэй саналууд зөрүүтэй байна. Байнгын хороон дээр хураасан саналууд зөрүүтэй байна. Ярилцаад ойлголцсон саналууд ингээд унаад эхэлж байна. Бидний яриад санал хураах ёстой асуудал орхигдсон байна. Авлигал, албан тушаалын хэргээр бид нар санал хураах ёстой. Санал хураалтын жагсаалт нь бас байхгүй байна. Харин ингэхээр дахиж Байнгын хороо хуралдмаар байна. Ажлын хэсэг дахиж хуралдъя. Бушуу туулай, борвиндоо баастай гэж ингэж яарч Сонгуулийн хууль батлахгүй. Ингэж хуралдахгүй ээ. Хаана алдаа гарсан алдаагаа олж засъя. Ажлын хэсэг дахиж хуралдъя. Тэгж байж Байнгын хороо хуралдъя. Тэгж байж чуулган хуралдъя. Ийм байдлаар явахгүй тийм. Өнөөдөр хуралдаандаа завсарлуул. Хурлын даргаа. Ийм байдалтай байж болохгүй нээрээ.

Байнгын хороо ажлын хэсэг дээр ярьсан зарчмын зөрүүтэй саналууд ойлголцсон ойлголтууд бүгд унаж байна. Бүгдээрээ алга болсон байна зарим нь. Ийм байдалтай явж болохгүй. Эвсэлтэй холбоотой заалтыг бид нар хураасан томъёоллоос шал өөр томъёолол орж ирж байна. Авлигал, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг бид санал хураах ёстой. Хураалтын жагсаалтад орж ирэхгүй байна. Жагсаалтыг бид нар ярьж байгаад бас оруулъя гэж ярьсан шүү дээ бас. Сонгогчдын нэрсийн жагсаалтыг ард түмэнд, юу намуудад өгье гэж. Үгүй ээ ийм байдлаар яваад байх юм. Нэг мөсөн цэгцэлье. Яарч сандраад одоо ажлын Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар ажлын хэсэг маань бас алдаанууд

гарч байх шиг байна. Энэ алдаануудаа нэлээн сайн нухацтай тайван ярилцаад шийдье.

Тэгэхгүй одоо юу гэдэг юм бие бие рүүгээ дайраад асуудалд хүрэхгүй ээ. Шийдэхгүй ээ. Жаахан нухацтай ярья. Ажлын хэсгээ дахиж хуралдуулъя. Чуулганаа завсарлуулаач. Ажлын хэсэг дахиж хуралдаад, Байнгын хороо дахиж хуралдаад явъя. Чуулган дээр ийм байдлаар явж болохгүй ээ гэсэн үг.

**Л.Энх-Амгалан:** Ингэе, Эрдэнэ гишүүнээ уучлалт гуйж байна. Сууж байгаарай. Тэртээ тэргүй энэ Сонгуулийн хууль бол тэртээ тэргүй бид нар зөвшилцлийн зарчмаар гаргах ёстой. Зөвшилцлийн зарчмаар. Улс төрийн нам. Тийм учраас Лүндээжанцан гишүүн бас горимын санал гаргаж байна. Энэ горимын саналыг цөмөөрөө дэмжье. Тийм. За.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр байна шүү дээ саяын 8 дугаар санал дээр хүмүүс шуугилдаад санал хураагаад тэгээд байна шүү дээ энийг ийм байна шүү, тийм байна шүү гэж ярьж байгаад тэгээд ойлголцохгүй аваачаад санал гарсан байхгүй юу. Ийм учраас энийг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Тэгээд ер нь Төрийн байгуулалтын хороо эргэж нэг цуглаад юмнуудаа яриад бүх гарцаагүй одоо хайрцагласан саналаа оруулж ирээд явъя. Заавал өнөө шөнө дуусгах гээд байх албагүй шүү дээ.

Тийм учраас энэ 8 дугаар 8-ынхаа горимын саналыг 8 дугаар 8-д байгаа юугаар саналыг дахин санал хураагаад хүчингүй болгох санал хураагаад тэгээд явъя. Тийм л дээ. Харин тэгээд би сая яриад байна шүү дээ дахиж.

**Г.Занданшатар:** Гишүүдээ энэ, эрхэм гишүүд ээ,

Энэ Сонгуулийн хуулийг маргаан зөрчилгүй, элдэв будилаангүй, нэг нам дангаараа хүч түрж биш, бас энэ намуудын үгийг сонсож, Сонгуулийн ерөнхий хороо байгууллагуудын саналыг үндэслэж ингэж эцэслэн батлах ёстой. Ингээд өнөөдрийн чуулганы хуралдаанаар Байнгын хороон дээр хэлэлцэж дэмжигдсэн саналууд тодорхойгүй шалтгаануудаар энэ буруу томъёологдож орж ирсэн. Зарим саналууд дэмжигдсэн саналууд орж ирээгүй ийм саатлууд гарсан учраас Төрийн байгуулалтын байнгын хороо дахиж хуралдаад, буруу туулай борвиндоо баастай. Одоо ирцтэй иж бүрэн хуралдаж маргааш хуулиа батална. Одоо ингэж юу яаж болохгүй.

Ийм учраас өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул битгий сандраад бай. Өнөөдрийн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Тийм.

Дууны бичлэгээс буулгасан:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА